



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ИРГЭНИЙН НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ХАРЪЯА ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
НИСЭХ БУУДЛЫН ДАРГА Д.ХИШИГБАТ
ТАНАА

2017.02.24 № 3/370

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Иргэнийн нисэхийн ерөнхий газрын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Иргэнийн нисэхийн ерөнхий газрын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Иргэнийн нисэхийн ерөнхий газрын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0224SAG48.Docx

070509



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ИНЕГ-ЫН ХАРЪЯА ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я. Самбууням
Утас: 260512
Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

**ТАБ-ын хаяг: ЗГ-ын IY байр
Бага тойруу 6 Улаанбаатар -46**

“Мишээл-Од Аудит” ХХК-ийн

Аудитын багийн ахлагч Т.Одончимэг
Утас: 99069029, 96659029

Ахлах аудитор: О.Цэндхүү
Ахлах аудитор: Б.Цогзолмаа
Аудиторын туслах: Э.Ундрах-Эрдэнэ
Аудиторын туслах: Э.Энхцэцэг
Утас: 99065204

Хаяг: БГД 2 хороо Time center 601, 603

Вэб хуудас: www.misheelodaudit.mn

Имайл хаяг: misheelod@yahoo.com

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3: Акт

Хавсралт 4: Менежментийн захидал

Хавсралт 5: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны талаарх мэдээлэл:
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

НЭГ. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэхь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ/2017/370/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудал нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 20-ноос 2017 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн багийн гишүүн “Мишээл-Од Аудит” ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг удирдан зохион байгуулж аудитор, туслах аудитор 4 ажилтан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. /ТАБ-СТА-А-9/

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 02 дугаар сарын 20-нд “Мишээл-Од Аудит” ХХК-д ирүүлсэн байна. Завсрын үеийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 13-наас 01 дүгээр сарын 25-ны хооронд, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 20-ноос 2017 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017

оны 02 дугаар сарын 25-нд ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудал нь Иргэний нисэхийн тухай хууль, Авто замын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын Ерөнхий хууль, зэрэг хуулиудын болон холбогдох хууль, тогтоол, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

БНМАУ-ын СнЗ-ийн 1956 оны 272-р тогтоолоор "Зарим аймагт агаарын шуудан ба тээврийн харилцаа байгуулах тухай" шийдвэр гарч "АН-2", "ЯК-12" ба бусад онгоцоор агаарын шуудан ба тээврийн харилцааг Ховд, Чойбалсан, Хөвсгөл аймгийн чиглэлд байгуулсан байна.

Иргэний нисэхийн салбарт аюулгүй, үр ашигтай, тогтвортой үйлчилгээ үзүүлэх эрхэм зорилготой. Алсдаа олон улсын зэрэглэл бүхий баруун болон төвийн бүсийн агаарын тээвэр зорчигч үйлчилгээний хүчирхэг зангилаа болох зорилттой.

2014 оноос УБ-Хөвсгөлийн чиглэлд хатуу хучилттай зам тавигдсанаар агаараар зорчих зорчигчийн урсгал багасч 2015 оноос нислэг улирлын чанартай болсон боловч үйл ажиллагаа хэвийн тасралтгүйгээр явагдаж байна.

Хөвсгөл Мөрөн нисэх буудлын онцлог нь Баруун болон Зүүн бүсийн бүх агаарын хөлгүүдийг хүлээж авахад бэлэн байх, аюулгүй байдлыг хангаж ажилладаг. Төвийн болон баруун бүсийн агаарын хөлгийг түлшээр цэнэглэх хүчин чадалтайгаараа орон нутгийн бусад нисэх буудлуудаас онцлог юм. Өнөөдөр Мөрөн нисэх буудлаар Геосан компанийн цесна 208 агаарын хөлөг, А-jet компанийн ЕС-145 агаарын хөлөг, Хүннү-айр компанийн Poker-50 ба Atr 72 агаарын хөлгүүд, AERO Mongolia компанийн-Poker-50 маркийн агаарын хөлөг, МАК-ийн Ми-8 болон Ми-171 гэсэн нисдэг тэрэг зорчиж байна.

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулж Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу ИНЕГ-аас томилсон Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын дарга нь захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэдэг.

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын даргын үүргийг гүйцэтгэж, нэгдүгээр гарын үсгийг Дэлгэрдалай овогтой Хишигбат, хоёрдугаар гарын үсгийг Энхтөр овогтой Энхцэцэг нар зурж хөрөнгийг зарцуулж байна.

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 17 чиглэлээр 39 уламжлалт сорил, 8 хяналтын сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай танилцахад Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн “МАКС” програмтай байна. Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Бид ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төлөвлөлтийн үед санхүүжилтын хуваарийг суурь болгон авч 1,241.1 сая төгрөгийн санхүүжилтын орлогын 1.0 хувиар материаллаг байдлын суурийг тооцож 12.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлийн үед санхүүжилт өссөн учир материаллагын түвшинг дахин тогтоож 1,267.7 сая төгрөгийн 1.0%-иар 12.7 сая төгрөгөөр тогтоон аудитын сорилуудыг гүйцэтгэхэд материаллаг хэмжээний зөрчил гараагүй болно.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын санхүүжилтыг ИНЕГ-аас баталж сар бүр хуваарийн дагуу арилжааны Голомт банкаар дамжуулан олгож, санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тайлант онд санхүүжилтаар 1,241.1 сая төгрөг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,241.1 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний орлогоор 26,6 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Найм. Шилэн дансны мэдээлэл

2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Шилэн дансны тухай хууль батлагдан мөрдөх болсонтой холбогдуулан, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2015 оноос хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

<http://www.shilendans.gov.mn/> цахим хуудсанд байгууллагаа бүртгүүлэн байгууллагын батлагдсан төсвийг зохих маягтын дугуу оруулж, төсвийн гүйцэтгэлийг сар бүр зохих маягтын дагуу байршуулсан байна.

<http://shilendans.gov.mn/> kod-028003502 /цахим хуудасны Төсвийн ил тод байдлын тухай гэсэн цэсэнд байгууллагын батлагдсан 2016 оны төсвийг байрлуулаад, төсвийн гүйцэтгэлийн 1-12 сарын мэдээ, харилцах, кассаас зарцуулсан зарцуулалтууд, тендерийн бүх мэдээлэл, худалдан авалтуудыг бүрэн байршуулаад байна.

Ёс. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 17 чиглэлд уламжлалт болон хяналтын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр уламжлалт 39, нарийвчилсан 8, нийт 47 горим, сорил гүйцэтгэв. Гүйцэтгэсэн сорилын үр дүнгээс харахад тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй бөгөөд ажлаас үндэслэлгүй халагдсан гэж шүүхээс шийдвэр гарснаас 14.7 сая төгрөгийн цалинг 4 хүнд нөхөн олгож байгууллагад үр ашиггүй зардал гаргасныг эс тооцвол үйл ажиллагааны үр дүн сайн байсан гэж бид үзсэн болно.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-З/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт ажил гүйлгээг 80,0 орчим хувь хамарсан байна. ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын үндсэн хөрөнгө нь 2016 онд ИНЕГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй байсныг жилийн эцэст уг байгууллагын санхүүгийн тайланд тусгуулан орлого, үр дүнгийн тайланд 4,994.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө борлуулсны олзыг тусгуулсан байна.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Завсрын аудитын явцад залруулагдах материаллаг дараах алдаа илэрсэнд аудитын зөвлөмж хүргүүлсэн болно. Үүнд:

1. Өмнөх удирдлага нь 2016 оны Б/57, Б/56, Б/42 тоот тушаалаар 3 ажилтанг ажлаас халсан боловч Хөвсгөл аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 09, 988 дугаар шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан гэж үзэж ажилд нь буцаан томилж нийт 7.7 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн олгосон байна.
2. ИНЕГ-ын даргын шийдвэрээр Захирал байсан М.Амарбаясгалан 2015 онд ажлаас халагдаж, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны 2015 оны 24 тоот шийдвэрээр ажилдаа эргэн орж 7.0 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн олгосон байна. Эдгээр зөрчил нь Иргэний хуулийн 497.1-д “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй”. 498.5-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй”. 513.2-д “Гэм хорыг хариуцвал зохих иргэн, хуулийн этгээд нь буцаан нэхэмжилсэн шаардлагын дагуу уг хуулийн этгээдийг хохиролгүй болгох үүрэгтэй” гэсэн заалтуудыг зөрчиж байна

Шийдвэрлэсэн нь: Байгууллагаас гарсан 14.7 сая төгрөгийн хохирлыг холбогдох хүмүүсээр төлүүлэхээр акт тогтоох

3. 2008 онд актлагдаж, ИНЕГ-т хүргүүлсэн 2 нэр төрлийн нийт 4.5 сая төгрөгийн станцыг үндсэн хөрөнгийн данснаас хасаагүй бүртгэлд тусгасан хэвээр байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 –р зүйлийн 13.4-т Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна гэсэн заалтыг биелүүлээгүй, үндсэн хөрөнгө биетээр оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

4. Тус байгууллагын шатахуун хадгалах саванд хадгалагдаж байгаа Изинис ХХК-ийн 401.4 кг, ИНЕГ-ын 66,292.3 кг бүгд нийлээд 66,693.7 кг шатахууны 70.4 кг буюу 175.0 мянган төгрөгийн хэвийн хорогдолыг авиа компаниудын шатахууны үлдэгдлээс хасч тооцоо нийлээгүй байна. Энэ нь ИНЕГ-ын Техник үйлчилгээний албаны даргын 2011 онд баталсан “ИНЕГ болон орон нутгийн нисэх буудлын шатахууны нярав-лаборантын гарын авлага”-ын 3.6-д заасан нефть бүтээгдхүүний хэвийн хорогдол тооцох аргачлалыг мөрдөж ажиллаагүй байна.

Тус байгууллага нь 4 авиа компани болон ИНЕГ-ын мэдлийн 84,397.62 кг шатахууныг агуулахад хадгалж, аюулгүй байдлыг хариуцан ажиллаж байна. Уг хадгалж байгаа шатахууны хадгалалтын хөлс 3.3 сая төгрөгийг тооцож аваагүй байна. Энэ нь ИНЕГ-ын даргын 2014.01.14-ны өдрийн А/08 дугаарын тушаалыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь Зөвлөмж өгөх

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Завсрын аудитын явцад ИНЕГ-ын даргын 2014.01.14-ны өдрийн А/08 дугаарын тушаалын дагуу 1 тн шатахууныг 1 хоногт 800 төгрөгөөр хадгална гэсэн заалтын дагуу авиа компаниудтай тооцоо нийлж авлага баталгаажуулан, санхүүгийн тайланд тусгах талаар зөвлөгөө өгсөн боловч 2005 оны тариф болох 1 тн шатахууныг 100 төгрөгөөр хадгалах тарифыг баримтлан тооцоо хийсэн байгааг залруулахаар зөвлөмж хүргүүлж байгаагаас өөр материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг баталгаажуулахаар аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгасан ба дараагийн аудитаар 2016 онд өгсөн акт, зөвлөмжийн биелэлтийг хянахаас гадна ИНЕГ болон салбар хоорондын тооцооны өглөг 251,8 сая төгрөгийн үлдэгдлийг мөшгөн шалгах, эдгээр асуудалд ИНЕГ-ын дотоод аудит анхаарал хандуулах хэрэгтэй байгаа талаар дурдах нь зүйтэй гэж бид үзлээ.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын явцад нийт 22.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 14.7 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 8.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч байна.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын харъяа Хөвсгөл аймгийн аудитын газрын хийсэн аудитаар 5 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 3 биелж, 2 зөвлөмж 50-90 %-ийн биелэлттэй байна. Зөвлөмжийн биелэлтийг ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын захирлын 2017 он 37 тоот албан тоотоор ирүүлснийг тайланд хавсаргасан болно.

Арван зургаа. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав.



ИНЕГ-ЫН ХАРЪЯА ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДАЛ

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: Naranchimegts@audit.gov

Аудитын менежер: Я. Самбууням
Утас: 260512
Цахим хаяг: sambuunyamyamya@audit.gov

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ЗГ-ын IY байр
Бага тойруу 6 Улаанбаатар -46

“Мишээл-Од Аудит” ХХК-ийн
Аудитын багийн ахлагч Т.Одончим
Утас: 99069029, 96659029

Үндсэн аудитор: Б.Цогзолмаа
Үндсэн аудитор: О.Цэндхүү
Аудитор: Э.Энхцэцэг
Аудитор: Д.Дэлгэрмаа
Утас: 99065204, 99065204
Хаяг: БГД 2 хороо Тайм центр 601,603
misheelod@yahoo.com

2017 оны 01 дүгээр сарын 25

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

Асуудал 1
Нефтийн бүтээгдхүүний хэвийн хорогдол,
хадгалалтын талаар..... 3

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

Асуудал 2
Үндсэн хөрөнгийн бүртгэлийн
талаар.....4



2017 оны 02 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын захиралд зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай компанийн үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ИНЕГ-ын харъяа Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

1. Тус байгууллагын шатахуун хадгалах саванд хадгалагдаж байгаа “Изинис” ХХК-ийн 401.4 кг, ИНЕГ-ын 66,292.3 кг бүгд нийлээд 66,693.7 кг шатахууны 70.4 кг буюу 175.0 мянган төгрөгийн хэвийн хорогдолыг авиа компаниудын шатахууны үлдэгдлээс хасч тооцоо нийлээгүй байна. Энэ нь ИНЕГ-ын Техник үйлчилгээний албаны даргын 2011 онд баталсан “ИНЕГ болон орон нутгийн нисэх буудлын шатахууны нярав-лаборантын гарын авлага”-ын 3.6-д заасан нефть бүтээгдхүүний хэвийн хорогдол тооцох аргачлалыг мөрдөж ажиллаагүй байна.
2. Тус байгууллага нь 4 авиа компани болон ИНЕГ-ын мэдлийн 84,397.62 кг шатахууныг агуулахад хадгалж, аюулгүй байдлыг хариуцан ажиллаж байна. Уг хадгалж байгаа шатахууны хадгалалтын хөлс 3.3 сая төгрөгийг тооцож аваагүй байна. Энэ нь ИНЕГ-ын даргын 2014.01.14-ны өдрийн А/08 дугаарын тушаалыг мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

1. Дүрэм, журам биелүүлээгүйгээс орлогын эх үүсвэрээ алдах /ЭҮ, Х, ИБ, ҮЗ/
2. Шатахууны хорогдлыг тооцоогүйгээс байгууллага алдагдал хүлээх, эд хариуцагч өрөнд орох /ЭҮ, Х, ИБ, ҮЗ/

ҮАГ-ын зөвлөмжүүд

1. “Изинис” ХХК-ийн 70.4 кг шатахууны хорогдлыг тооцоо бодсон акт үйлдэж баталгаажуулах.
2. Авиа компаниудын 2016 онд хадгалуулж байгаа шатахууны хадгалалтын хөлс 3.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан санхүүгийн тайланд авлагаар бүртгэх мөн өмнөх онуудад аваагүй шатахуун хадгалалтын хөлсийг нөхөн тооцоо хийж авах, 2014 оны А/08 тушаалаар батлагдсан үнийн тарифыг нэмэгдүүлэх асуудлыг ИНЕГ-т тавих

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж, жилийн эцсийн тайланд залруулж, цаашид ИНЕГ-ын ТҮА-ны даргын 2011 онд баталсан “ИНЕГ, орон нутгийн нисэх буудлын шатахууны нярав-лаборантын гарын авлага”-ын 3.6-д заасан нефть бүтээгдхүүний хэвийн хорогдол тооцох аргачлал мөн ИНЕГ-ын даргын 2014.01.14-ны өдрийн А/08 дугаарын тушаалыг мөрдөж ажиллана.

Асуудал 2: Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар

**Тэргүүлэх ач
холбогдол № 2**

ҮАГ-ын ажиглалт

батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

1. 2008 онд актлагдаж, ИНЕГ-т хүргүүлсэн 2 нэр төрлийн нийт 4.5 сая төгрөгийн станцыг үндсэн хөрөнгийн данснаас хасаагүй бүртгэлд тусгасан хэвээр байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 –р зүйлийн 13.4-т Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна гэсэн заалтыг биелүүлээгүй, үндсэн хөрөнгө биетээр оршин байх гэсэн

ҮАГ-ын зөвлөмжүүд

1. ИНЕГ-т хүргэгдсэн 2008 онд актлагдсан 4.5 сая төгрөгийн 2 ш станцыг үндсэн хөрөнгийн данснаас хасуулахаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт санал хүргүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж 2017 онд шийдвэрлүүлнэ.

Эрсдлүүд

1. Хөрөнгө үнэ цэнэ алдаж, ашиглах боломжгүй болох /ИБ, ЭБ, ТБ/
2. Байгууллагын санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх /ИБ, ЭБ, ТБ/

ИНЕГ-ЫН ХАРЬЯА ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 Î Í Û ÄËËËËÍ ÝÖÑËËÍ
ÑÀÍ Õ—ÄËËÍ ÄÄËÄËÛ Í ÒÄËËÄÍ

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

ᠮᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ	Аудитаар баталгаажсан үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,870,057.75	11,396,445.73
Дансны авлага		17,940,964.80
Татвар, НДШ-ийн авлага		400,781.00
Бусад авлага	316,000.01	2,986,475.01
Бусад санхүүгийн хөрөнгө		0.00
Бараа материал	261,315,090.27	231,963,319.24
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн	268,501,148.03	264,687,985.78
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө		14,025,999,491.60
Биет бус хөрөнгө		
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Хуримтлагдсан элэгдэл		9,031,036,669.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		4,994,962,822.60
НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН	268,501,148.03	5,259,650,808.38
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг		
Цалингийн өглөг		
Татварын өр		
НДШ - ийн өглөг	98,995.00	
Богино хугацаат зээл		
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого		
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр	214,885,579.99	251,765,300.35
Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	214,984,574.99	251,765,300.35
Урт хугацаат өр төлбөр		

Урт хугацаат зээл		
Нөөц /өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Өр төлбөрийн нийт дүн	214,984,574.99	251,765,300.35
Эздийн өмч		
Өмч: - төрийн		
- хувийн		
- хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	53,516,573.04	5,007,885,508.03
Тайлангийн үеийн ашиг		
Өмнөх үеийн ашиг		
Эздийн өмчийн дүн	53,516,573.04	5,007,885,508.03
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	268,501,148.03	5,259,650,808.38

ИНЕГ-ЫН ХАРЬЯА ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 Î Í Û ÆËËËËÍ ÝŎÑËËÍ
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Аудитаар баталгаажсан дүн	
	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого (цэвэр)	1,335,027,997.46	1,267,697,675.76
Борлуулалтын өртөг	1,164,088,250.03	1,140,029,049.06
Нийт ашиг(алдагдал)	170,939,747.43	127,668,626.70
Түрээсийн орлого		
Хүүний орлого	1,182,823.76	1,184,947.92
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	2,754,846.00	46,216,223.73
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	57,490,482.46	65,056,819.87
Санхүүгийн зардал		
Бусад зардал	82,077,850.00	97,090,293.05
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		4,994,962,822.60
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	35,309,084.73	5,007,885,508.03
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)	35,309,084.73	5,007,885,508.03
Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	35,309,084.73	5,007,885,508.03
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн	35,309,084.73	5,007,885,508.03
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

ИНЕГ-ЫН ХАРЬЯА ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН АУДИТ ХИЙГДСЭН

2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөг)

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэл тийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Өмчийн дүн
2014 оны 01 сарын 01-ний үлдэгдэл							-
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-		-
Тайлант үеийн цэвэр ашиг							-
Бусад дэлгэрэнгүй орлого							-
Өмчид гарсан өөрчлөлт							-
Зарласан ногдол ашиг							-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							-
2016 оны 01 сарын 01-ний үлдэгдэл						53,516,573.03	53,516,573.0
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
Залруулсан үлдэгдэл						53,516,573.03	53,516,573.0
Тайлант үеийн цэвэр ашиг						5,007,885,508.03	5,007,885,508.0
Бусад дэлгэрэнгүй орлого							-
Өмчид гарсан өөрчлөлт						(53,516,573.03)	(53,516,573.0
Зарласан ногдол ашиг						-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							-
Аудитлагдсан 2016 оны 01 сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-	-	5,007,885,508.03	5,007,885,508

ИНЕГ-ЫН ХАРЬЯА ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 Í Í Ò ÆËËËËÍ ÝÕÑËËÍ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Аудитаар баталгаажсан дүн	
	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	1,279,728,490.77	1,254,508,073.12
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
лавлагааны орлого		
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,250,000.00	
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого	1,268,692,954.54	1,241,122,369.12
Бусад мөнгөн орлого	8,785,536.23	13,385,704.00
Мөнгөн зарлагын дүн (-)	1,276,967,616.03	1,251,166,633.07
Ажиллагчдад төлсөн	706,310,047.20	688,368,380.41
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	175,135,215.05	166,244,756.07
Бараа материал худалдан авахад төлсөн	50,933,833.90	56,377,062.40
Ашиглалтын зардалд төлсөн	62,766,615.35	67,920,982.70
Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	77,789,786.00	65,814,575.56
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	107,786,033.00	159,601,979.92
Даатгалын төлбөрт төлсөн	17,941,100.00	18,013,102.57
Бусад мөнгөн зарлага	78,304,985.53	28,825,793.44
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,760,874.74	3,341,440.05
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Мөнгөн орлогын дүн (+)	1,182,823.76	1,184,947.92
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	1,182,823.76	1,184,947.92
Хүлээн авсан ногдол ашиг		
Бусад		
Мөнгөн зарлагын дүн (-)		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		

Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Бусад		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,185,823.76	1,184,947.92
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Бусад		
Мөнгөн зарлагын дүн (-)		
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Бусад		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,943,698.50	4,526,387.97
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,926,359.25	6,870,057.75
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,870,057.75	11,396,445.72